



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

додг. Д. Дэл № *107/02*

танай _____-ны № _____-т

Мэдээлэл хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн нэгдсэн хуралдаанд хийх Соёлын харилцаа, хамтын ажиллагааг дэмжих, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээний талаарх Ерөнхий сайдын мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт ⁰⁶..... хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

СОЁЛЫН ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ, СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ХИЙХ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Засгийн газраас Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Соёлын салбарын стратеги төлөвлөгөө” зэрэг урт болон дунд хугацааны баримт бичгүүд болон Соёлын тухай хууль, Соёлын өвийн тухай хууль, Кино урлагийг дэмжих тухай хуульд заасны дагуу Монгол үндэстний оршин тогтнох амин чухал дархлаа болох үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалах, хөгжүүлэх, дэлхийн улс орнуудтай соёлын хамтын ажиллагааг өргөжүүлж, дипломат төлөөлөгчийн газрууд болон иргэдээрээ дамжуулан дэлхий дахинд сурталчлах, улс орныхоо гадаад нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлэх ажлыг эрчимжүүлэхэд онцгой анхаарал хандуулан ажиллаж байна.

Соёлын бодлого бүх шатанд харилцан уялдаатайгаар хэрэгжсэнээр Монгол Улсыг гадаад улсад сурталчлах соёлын харилцаа, хамтын ажиллагаа сайжрах, Монгол Улсын нэр хүнд олон улсад өсөх, өрсөлдөх чадвар нэмэгдэх, улмаар эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх боломж бүрдэх юм.

Соёлын салбарын тэргүүлэх бодлого, стратегиар дамжуулан Монгол Улсыг олон улсад сурталчлах, соёлын гадаад харилцаа, хамтын ажиллагаа, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Нэг. Монгол Улсыг олон улсад сурталчлах чиглэлээр

Засгийн газар Монгол Улсыг олон улсад сурталчлах үйл ажиллагааг идэвхжүүлэх нэгдсэн стратеги, төлөвлөгөөг хөрөнгө оруулалт, аялал жуулчлал, хүний эрх, ардчилал-сайн засаглал-цахим хөгжил гэсэн дөрвөн үндсэн зорилтын хүрээнд батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд Засгийн газрын 2023 оны 103 дугаар тогтоолоор Монгол Улсын олон улс дахь сурталчилгаа, мэдээллийн Үндэсний хороог Соёлын сайдаар ахлуулан шинээр байгууллаа.

Үндэсний хорооны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд 2023 оны 08 дугаар сарын 19-ний өдөр Улаанбаатар хотноо “Nas Summit-2023” арга хэмжээг зохион байгуулав. Тус арга хэмжээнд олон улсын болон Монголын шилдэг контент бүтээгч, хөрөнгө оруулагчид оролцож, өөрсдийн туршлага, арга барилаасаа хуваалцсаны зэрэгцээ цахим нийгмийн сүлжээнд олон сая дагагчтай 10 орны 19 нөлөөлөгч нар долоо хоногийн хугацаатай Монгол Улсаар аялж, “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалд хүрэлцэн ирж, өөрсдийн хийсэн Монгол Улсын тухай 40 контентыг Instagram, Facebook, Tiktok, Youtube зэрэг цахим платформоор түгээсэн нь 150 сая гаруй үзэлт, хандалт авсан байна.

Мөн Монгол Улсыг олон улсад сурталчлах, аялал жуулчлалын салбарт эерэг сэтгэгдэл бий болгох зорилгоор олон улсын хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, уг ажлын хүрээнд АНУ-ын CNN телевизтэй богино хэмжээний видео нэвтрүүлгийг бэлтгэсэн. Үүнд:

- Монголд үйлдвэрлэв: Ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэл, байгаль орчинд ээлтэй загварын салбарын талаарх шоу нэвтрүүлэг (2023 оны 07 дугаар сарын 01-03-ны өдөр);

- Монголд үйлдвэрлэв: Байгальд ээлтэй ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэл (2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр);
- CNN телевизийн алдарт хөтлөгч Ричард Күэстийн “Quest Means Business Монголд” богино хэмжээний 9 цуврал видео (2023 оны 08 дугаар сарын 16-18-ны өдөр);
- Аялал жуулчлалын салбарын тухай Spirit of Mongolia богино хэмжээний нэвтрүүлэг (2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр);
- Аялал жуулчлал, соёл, хоол хүнсний талаарх нийт 5 өгүүллэг;
- Оюу Толгой төсөл болон уул уурхайн салбарын хөгжлийн талаар сурвалжилга, нэмэлт сурталчилгаа, контент;
- Соёлын өв, орчин үеийн хөгжлийн талаарх сурталчилгаа (2023 оны 08 дугаар сарын 29-09 дүгээр сарын 04-ний өдөр) зэрэг болно.

Монгол Улс олон улсад бизнес, хөрөнгө оруулалт, аялал жуулчлал, ашигт малтмал зэрэг сэдвээр илүү их танигдах болсон бөгөөд CNN телевизтэй хамтын ажиллагаа эхлүүлснээс хойш Монголын талаарх эерэг ойлголт 38 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Цаашид тус байгууллагатай хамтран Монгол Улсыг сурталчлах ажлыг үргэлжлүүлэх бөгөөд зохих бэлтгэл ажлыг төлөвлөн хангаж байна.

Монголын түүх, соёлыг гадаадад сурталчлах ажлын хүрээнд Бүгд Найрамдах Франц Улсын Нант хотын Түүхийн музейд “Чингис хаан: Монголчууд дэлхийг өөрчилсөн нь” үзэсгэлэнг 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр нээсэн бөгөөд энэ үеэр эрдэм шинжилгээний бага хурал, жижиг, дунд үйлвэрлэлийн үзэсгэлэн худалдаа, орчин үеийн дүрслэх урлагийн үзэсгэлэн зэргийг зохион байгууллаа.

Түүнчлэн Засгийн газар 2022-2025 оныг Монголд зочлох жил болгон зарласны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын БНСУ, БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр “Монголд тавтай морилно уу” цогц арга хэмжээний соёл урлагийн тоглолт, арга хэмжээг тус тус зохион байгуулав.

Цаашид гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах бодлогын хүрээнд соёлын харилцааг өргөжүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, Монгол Улсыг олон улсад сурталчлан таниулах, Монгол Улс, монгол хүний талаарх эерэг ойлголт, сэтгэгдэл төрүүлэхэд чиглэсэн хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор аливаа гадаад сурталчилгаа, гадаад үйл ажиллагаанд Монгол Улсын дүр төрх, үндэсний онцлог, мөн чанарыг илэрхийлсэн агуулга бүхий “Go Mongolia” түлхүүр үгийг хэрэглэж байхаар тогтсон болно.

Хоёр. Соёлын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр

I. “Монгол урлаг дэлхийн тайзнаа” аяны хүрээнд:

Монголын түүх, соёлыг гадаадад сурталчлах ажлын хүрээнд Улсын Филармонийн Морин хуурын чуулгын тоглолтыг Австралийн Холбооны Улсын Сиднейн дуурийн театр, Бүгд Найрамдах Франц Улсын Версалийн Хааны ордон болон Нант хотын Консерватори, БНХАУ-ын Шанхай хотын Симфони оркестрийн их танхимд, Үндэсний урлагийн их театрын тоглолтыг БНСУ-д тус тус амжилттай зохион байгуулахын зэрэгцээ ХБНГУ-д зохион байгуулагддаг дэлхийн нэр хүндтэй, олон улсын “Jazzahead” жазз хөгжмийн фестивалд Улсын Филармонийн Баянмонгол чуулгыг оролцууллаа.

“Олон улсын тэргүүлэх зэрэглэлийн наадамд оролцох тухай” Засгийн газрын 2022 оны 73 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор 76 дахь удаагийн Каннын кино наадамд Монголын кино асрыг байгуулан, Кино урлагийг дэмжих тухай хуулийг танилцуулж, кино зураг авалтын буцаан олголт, зураг авалтын байршлуудыг сурталчлан, Монголын кино өдөрлөгийг зохион байгуулснаас гадна тус наадмын үеэр зохион байгуулагддаг сургалтад кино урлагийн салбарын уран бүтээлчдийг хамруулав.

Каннын олон улсын кино наадмын “Ан Сөртн Регард” (Un Certain Regard) хэсэгт найруулагч П.Золжаргалын “Баавгай болох сон” бүтээл сонгогдсон нь монгол кино анх удаа тус кино наадмын тусгай төрөлд нэр дэвшсэн үйл явдал болсон.

Түүнчлэн уг кино наадмын үеэр Монгол Улсын Кино урлагийн зөвлөл БНСУ, Филиппин, Сингапур, Тайвань, Малайз, Индонез гэсэн 6 орны Засгийн газрын кино урлагийн зөвлөлтэй дугуй ширээний уулзалтыг зохион байгуулж, улмаар хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд Азийн кино холбоодын нэгдсэн сүлжээ (Asian Film Alliance Network)-г хамтран үүсгэн байгууллаа. Түүнчлэн БНСУ-ын Кино урлагийн зөвлөлтэй Хамтран ажиллах тухай санамж бичиг байгуулав.

Мөн 2023 оны 09 дүгээр сард зохион байгуулагдсан Венецийн 80 дахь удаагийн олон улсын кино наадамд найруулагч П.Лхагвадуламын “Сэр сэр салхи” уралдаант хэсэгт шалгарч, шилдэг эрэгтэй дүрийн шагнал хүртсэн.

Монголын уран бүтээлчдийн оюуны бүтээлийг олон улсад таниулан сурталчлах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх чиглэлээр “Тамгагүй төр” жүжгийг Их Британийн Лондон хотын театрт тоглуулах ажилд бодлогын дэмжлэг үзүүлэв. Энэхүү жүжиг Монгол Улсын соёл, урлагийн хөгжлийг олон улсад эергээр таниулан сурталчилсан бөгөөд нийт 40 гаруй мянган үзэгч үзээд байна.

Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр Бүгд Найрамдах Итали Улсын Флоренцийн их сургууль болон Пармагийн их сургуульд Монголын соёлын төвийг 2024 онд байгуулах чиглэлээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойг тохиолдуулан “Хархорум” олон улсын кино наадмыг 2023 оны 12 дугаар сарын 07-12-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд Венец, Пусан, Берлин, Токиогийн кино наадмуудад өрсөлдсөн болон Оскарын шагналт найруулагчийн зэрэг 22 уран сайхны болон баримтат киног олон нийтэд толилууллаа.

II. “Дэлхийд тархсан Монгол өв” аяны хүрээнд

Дэлхийд тархсан монгол соёлын өвийг судлан шинжлэх, хадгалж хамгаалах чиглэлээр ОХУ-д хадгалагдаж байгаа монголын соёл, баримтат өв, түүхийн эх сурвалж, архивын баримт, гар бичмэл зэргийг хамтран эрж хайх, хуулбарлах, Ноён уулын булшнаас олдсон олдворуудыг Монгол Улсад гэрээ ёсоор эргүүлэн авчрах чиглэлээр хамтран ажиллах, ОХУ-ын Эрмитаж музейд хадгалагдаж байгаа Ноён уулын олдворуудыг судлах, эдгээр олдворуудаар тус музейд болон Монгол Улсад үзэсгэлэн дэлгэх, хадгалагдаж буй үзмэрүүдийн “А” хуулбарыг авах зэрэг асуудлыг ОХУ-ын Санкт Петербург хотноо 2023 оны 11 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Санк-Петербургийн олон улсын соёлын форум”-д

оролцохдоо оросын талд тавьж, энэ үеэр зохион байгуулагдсан "Ноён уул 100 жилийн туршид" эрдэм шинжилгээний хурлаар Ноён уулын дэлхийн шинжлэх ухаанд оруулсан хувь нэмрийг илүү тодруулан гаргаж, ирээдүйд хэрхэн судлах, хадгалах, хамгаалах зэрэг тодорхой асуудлуудыг хэлэлцлээ.

Бүгд Найрамдах Франц Улсын нийслэл Парис хотноо 2023 оны 05 дугаар сард хуралдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (UNESCO)-ын "Дэлхийн дурсамж" хөтөлбөрийн Олон улсын зөвлөлдөх хорооны хурлаар Олон улсын баримтат өвийн жагсаалтад "Халхын цогт Хунтайжийн хадны бичээс" бүртгэгдлээ.

Түүнчлэн Саудын Арабын Хаант Улсад 2023 оны 09 дүгээр сарын 14-19-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Дэлхийн өвийн хорооны 45 дугаар чуулганаар Буган чулуун хөшөө, хүрлийн үеийн холбогдох дурсгалууд Дэлхийн өвийн жагсаалтад тус тус бүртгэгдэв.

Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээлч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болох зорилтын хүрээнд зохион байгуулсан "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивальд БНХАУ, ОХУ, Бүгд Найрамдах Турк Улс, БНСУ, Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Киргиз Улс, Унгар Улсын зэрэг улсын нийт 100 гаруй өвлөн уламжлагчид урлагийн тоглолт толилуулж, гар урлалын бүтээлээ танилцуулав. Мөн энэ үеэр НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын судалгааны хүрээлэнгүүдийн төлөөллийг оролцуулсан "Амьд өвийн ирээдүйг тодорхойлох нь: 2003 оны Конвенцийн 20 жилийн ой ба хамтын ажиллагааны хэтийн төлөв" олон улсын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, "Нүүдлийн соёлын өвийг хамгаалах нь" тунхаглалыг батлан гаргалаа.

Гурав. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн Тогтвортой хөгжлийн дээд хэмжээний 2015 оны чуулга уулзалтаар баталсан Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд соёл, бүтээлч байдал болон соёлын олон төрөл зүйлийг тогтвортой хөгжилд тулгарч байгаа саад бэрхшээлийг даван туулах гол хөшүүрэг гэж үзэж, улмаар үндэсний болон олон улсын хөгжлийн бодлого, түүнчлэн хөгжлийн төлөөх олон улсын хамтын ажиллагааны чиглэлийг боловсруулахдаа соёлыг онцгой чухал бүрэлдэхүүн хэсэг болгон авч үзэх нь зүйтэй гэж үзсэн билээ.

Соёлын бүтээлч үйлдвэрлэл нь хөрөнгө оруулалтыг татах замаар ажлын байр, нэмүү өртгийг бий болгох, улс орныг сурталчлах, улс үндэстний өвөрмөц байдал, оюуны дархлааг тодорхойлж, "зөөлөн хүч"-ний бодлого болохоос гадна соёлын контентоор дамжуулан мэдээллийг иргэдэд хүртээмжтэйгээр түгээх замаар тэдний итгэл үнэмшлийг бий болгож, соёлын олон талт байдлыг сурталчлан, хүн ардыг соён гэгээрүүлэх, оюуны дархлааг бий болгох зэрэг нийгэм, эдийн засгийн чухал ач холбогдолтой юм.

Дэлхийн өнцөг булан бүрд улс орнууд соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих төрөл бүрийн бодлогыг санаачлан соёлын бүтээлч үйлдвэрлэлийн өлгий нутаг болохыг эрмэлзэж байна.

Манай улсын хувьд ч дэлхий нийттэй хөл нийлүүлэн алхаж, соёлын салбарын нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, салбарын ДНБ-д эзлэх хувийг 2030 он гэхэд 4 хувьд хүргэх зорилт тавин ажиллаж байна.

Энэхүү зорилтын хүрээнд Засгийн газрын 2022 оны 314 дүгээр тогтоолоор Төрөөс дэмжлэг үзүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх 6 чиглэл (2022-2027 он), мөн Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих 8 зорилт бүхий 61 арга хэмжээ (2022-2030 он)-г баталж, хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө, үр дүнгийн шалгуур үзүүлэлт, шаардлагатай хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр зэргийг тодорхойлон бодлогын хувилбаруудыг боловсруулсан.

Түүнчлэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дэмжлэгийг бий болгож, олон улсын тавцанд өрсөлдөх чадвартай соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх замаар олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгох зорилго бүхий Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын бүтээлч хотуудын сүлжээнд Улаанбаатар хот 2023 оны 11 дүгээр сард нэгдлээ. Цаашид Дархан-Уул, Өвөрхангай, Дорноговь аймгуудын нутаг дэвсгэрийн хуваарилалт, бүсчлэлийн түүхэн хандлага, зохион байгуулалтын хэлбэр, бүс нутгийн онцлог, өрсөлдөх чадварт тулгуурласан соёлын бүтээлч үйлдвэрлэлийн орон зайн төлөвлөлт, зураглалыг гаргасан бөгөөд эхний ээлжид Дархан-Уул аймгийг Кинонд ээлтэй хот болгон хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна. Энэ хүрээнд Дархан хотод кино үйлдвэрлэлийн зураг авалтын павильон байгуулах газар болон дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх, бүтээн байгуулалтад зориулсан зардлыг Кино урлагийг дэмжих сангаас санхүүжүүлэх, дэмжлэг үзүүлэх, Дархан хотод түүхэн болон бүх цаг үеийн кино зураг авахад тохиромжтой объект, барилга байшингийн өнгө төрхийг хадгалах үүднээс тэдгээр газруудыг соёлын өвийн чиглэлээр хадгалан үлдээхэд анхаарах, Дархан-Уул аймагт кино урлагийн салбар зөвлөл байгуулах, Дархан кино фестиваль зохион байгуулах, киноны хүний нөөцийг бэлтгэх сургалт, хувцас техник хэрэгслийн сан бүрдүүлэх зэрэг ажлуудыг төлөвлөн эхлүүлээд байна.

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод 2023 оны 09 дүгээр сард зохион байгуулагдсан "Монгол-Хятадын ЭКСПО" дөрөв дэх удаагийн арга хэмжээний соёлын солилцооны хөтөлбөр болон 10 дугаар сард Бүгд Найрамдах Франц Улсын Нант хотод зохион байгуулагдсан "Чингис Хаан: Монголчууд дэлхийг хэрхэн өөрчлөв" хамтарсан үзэсгэлэнгийн нээлтийн үеэр соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын жижиг, дунд үйлдвэрлэгчдийн үзэсгэлэнг зохион байгуулж, удирдлага, зохицуулалтаар ханган ажиллалаа.

Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дахь Хөшигийн хөндийн 31 мянган га газрын 1000 га-д нь Эдийн засгийн чөлөөт бүсийг Аялал жуулчлалын цогцолбор, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор, Худалдаа үйлчилгээний төв, Мэдээлэл технологийн кластер, Олон улсын санхүүгийн төв гэсэн байдлаар бүсчлэн төлөвлөж, үйлчилгээний салбарын эдийн засгийг хөгжүүлэхээр холбогдох шийдвэрийг гаргасан бөгөөд цогцолборын байршлыг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгуулаад байна.

Уг цогцолбор нь соёлын үйлдвэрлэл эрхлэгчдийг орон зайн хувьд нэг дор цугларч хамтран ажиллах, суралцах, хөгжих бололцоогоор хангаж, өртөг зардал хэмнэхийн зэрэгцээ гадаадын томоохон студи, продакшн, хөрөнгө оруулагчдыг татах зорилготой.

Түүнчлэн Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах чиглэлээр “Монгол кино нэгтгэл” ТӨААТҮГ-ын талбайд Олон талт арга хэмжээний танхимыг байгуулахаар холбогдох ТЭЗҮ-ийн судалгааг боловсруулсан.

Соёл, урлагийг хөгжүүлэх, сурталчлан таниулах, соёлын өвийг бүртгэх, судлах, хадгалан хамгаалах, сэргээн засварлах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилго бүхий Соёл, урлагийг дэмжих сангаас нийт 19 төсөлд 651,602,700 төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлэж, эхний санхүүжилтийг олгоод байна.

Соёлын яамнаас “Соёлын бүтээлч сар” цогц арга хэмжээг 2021, 2022, 2023 онуудад гурван жил дараалан 11 дүгээр сард буюу бүтэн сарын туршид энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэд, хувийн хэвшил, албан байгууллагуудтай хамтран амжилттай зохион байгууллаа.

-----oOo-----